



ЭРДЭС БАЯЛГИЙН СУДАЛГАА, ГЕОМЭДЭЭЛЭЛ СУРГАЛТЫН ТӨВ

Танилцуулга

Тус төвийг 2011 онд профессор Г.Ухнаа үүсгэн байгуулсан. Геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл хайгуулын ажлыг шинжлэх ухааны онолын өндөр түвшинд, шинэ дэвшилтэд арга, технологийг нэвтрүүлэн гүйцэтгэж, геологи хайгуулын судалгааны ажлын үр өгөөжийг дээшлүүлэн, орчин үеийн олон улсын жишиг шаардлагад нийцүүлэх үндсэн зорилготой.

Олон улсын чиг хандлагад нийцсэн чанартай, хайгуулч инженерүүдийг бий болгохын төлөө хамтран ажилладаг, туслан дэмждэг хамт олон, харилцагч байгууллага, геологич, хайгуулч, судлаач, оюутан залуус та бүхэнд талархал илэрхийлж, ашигт малтмалын ордын эрэл, хайгуул, судалгаа шинжилгээний ажилд тань амжилт хүсье.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл

- Геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл хайгуулын ажлын ажил эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгөх, шинжээчийн дүгнэлт гаргах, ажлын төсөл, үр дүнгийн тайлан боловсруулах.
- Геологийн зураглал, ашигт малтмалын эрэл хайгуулын ажлыг аж ахуйн гэрээгээр гүйцэтгэх.
- Ашигт малтмалын ордны нөөцийн тооцоол, эдийн засгийн үнэлгээний орчин үеийн өндөр хүчин чадалтай программуудыг эзэмшиж, нутагшуулах, геологийн мэргэжилтнүүдийг сургах.
- Бүс нутгийн геологийн тогтоц, ашигт малтмал, эрэл хайгуулын чиглэлээр сэдэвчилсэн судалгаа явуулах.
- Геологийн салбарын инженерүүдэд мэргэжлийн зэрэг олгох сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах.
- Харьяа салбарын сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, сургалтын орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглон, сургалт явуулах хамгийн таатай орчныг бүрдүүлж ажиллах.
- Геологийн салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийг дээшлүүлэх сэдэвчилсэн сургалт, курсүүдийг тогтмол зохион байгуулах.
- Мэргэжлийн сурах бичиг, гарын авлага боловсруулж хэвлүүлэх, геологийн үйлдвэрлэлийн ажлын норм, стандарт, заавруудыг боловсруулах үйл ажиллагаанд оролцох.

- Геологийн салбарын итгэмжлэгдсэн инженерүүдийг бэлтгэх талаар өөрийн орны болон олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх.
- Геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл хайгуулын чиглэлээр олон улсын хурал, семинар зохион байгуулах, багш ажилтнуудыг оролцуулах.
- Салбарын профессор багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, өөрийн орны хэрэгцээ, мэргэжлийн чиглэлийг харгалзан гадаадын их дээд сургуулиудтай холбоо тогтоон залуу багш нарыг сургаж бэлтгэх.





Төвийн эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд



➤ 2019-2023 онд Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны захиалгат “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж” боловсруулах төслийг 5 үе шатаар хэрэгжүүлсэн. Монгол Улсын нутаг дэвсгэрт тогтоогдсон, улмаар хайгуул, олборлолтын ажлыг явуулж, улсын эдийн засагт онцгой нөлөө үзүүлж байгаа болон үзүүлэх боломжтой голлох 30 орчим ашигт малтмалын төрлөөр, хайгуулын ажлын 5 багц, цуврал “Аргачилсан зөвлөмж”-үүдийг манай шилдэг 80 орчим судлаач, мэргэшсэн ба зөвлөх геологич-хайгуулчид 5 жилийн дотор оролцон боловсруулж, англи хэлээр орчуулагдсан нь геологийн салбарт анх удаа бөгөөд түүхэн үүрэг гүйцэтгэлээ.

1. **Аргачилсан зөвлөмж-I** (2019): Уран-тори, нүүрс, төмөр, алт, шороон орд, хайлуур жонш, зэс, газрын тос
2. **Аргачилсан зөвлөмж-II** (2021): Цайр-хар тугалга, молибден, мөнгө, вольфрам, цагаан тугалга
3. **Аргачилсан зөвлөмж-III** (2021): Хөнгөн цагаан, бал чулуу, давс, лити-цеци, газрын ховор элемент, карбонат чулуулаг, элс-хайрга
4. **Аргачилсан зөвлөмж-IV** (2022): Фосфат (фосфорит), манган, берилли, никель-кобальт, хром
5. **Аргачилсан зөвлөмж-V** (2023): Барилгын ба өнгөлгөөний чулуу, Цахиурлаг чулуулаг, Шаварлаг чулуулаг, Гөлтгөнө ба ангидрит, Өнгөт ба эрдэнийн чулуу



➤ Дээрх аргачилсан зөвлөмжүүдийг боловсруулах явцад цуглуулсан баримт материал мэдээлэлд тулгуурлан проф Г.Ухнаа удирдан 8 төрлийн ашигт малтмалын 9 боть цуврал ном туурвисан нь өдгөө хайгуулч геологичдын ширээний ном болоод байна.





➤ Мэргэшүүлэх богино сургалтуудыг зохион байгуулж байна. Жишээ нь Эрдэнэт ТӨҮГ-тай хамтран “Минералогийн шинжилгээний үндэс Модул 1”, “Эрэл хайгуулын геохимийн арга”, “Порфир ордын хүдэржилт, хувирал, эрэл хайгуулын оновчлол” сургалтууд орсон.



2010 онд анх Геологичдод “Зөвлөх, мэргэшсэн” зэрэг олгох сургалт явуулж эхэлсэн ба одоо мэргэшүүлэх богино сургалт явуулж байна.

➤ Ашигт малтмалын ордын эрэл хайгуулын сэдэвчилсэн судалгаа, хайгуулын ажил гүйцэтгэх, арга зүйн зөвлөгөө өгөх, шинжээчийн дүгнэлт гаргах, ажлын төсөл, үр дүнгийн тайлан боловсруулахад оролцож байна.





Төвийн бүрэлдэхүүн



Овог нэр: Баасандорж, Алтанзул

Албан тушаал: Төвийн захирал

Эрдмийн зэрэг, цол: Доктор /PhD/ дэд профессор



Овог нэр: Гэндэн Ухнаа

Албан тушаал: Зөвлөх

Эрдмийн зэрэг, цол: Доктор /PhD/, профессор

Холбоо барих

Утас: 88113837

Е-мэйл хаяг: altanzul@must.edu.mn